




ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /Жилийн эцэс/

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилдээ	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	-12 ба дээш мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	Байгууллагын цахим хуудасны Авлигатай тэмцэх үйл ажиллагаа буланг шинээр гаргаж авлигатай тэмцэх төлөвлөгөө, тайлан, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар, урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлт, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд булангууд ил байршуулан холбогдох мэдээллийг тухай бүр оруулан ажилласан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Үйлийн үр хаяг андуурдаггүй”, “Авлигын гэмт хэрэг” дугаар 2, 3, Авлигатай тэмцэх газрын мэдээлэл нэвтрүүлэг, “найруулагч У.Пүрэвжав:Ирээдүйг хамгаалах, хайрлах хамгийн зөв арга бол авлигыг тэвчих” зэрэг видео, нэвтрүүлэг, сторкуудыг байгууллагын цахим хуудасны урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх булан байршуулсан. “Хуулийн засаглал”: авлига, албан тушаалын гэмт хэрэгт хуулийн хатуу хариуцлага тооцдог, ялын бодлогыг чангатгах цаг болсон, Гадагш шилжүүлсэн хууль бус мөнгө хөрөнгийг олж илрүүлэн ажиллаж байна, Авлигын эрсдэл бууруулах 10 арга, Европын холбооноос улс орнуудад үйлдэгдсэн авлигын гэмт хэрэгтэй тэмцэх дүрэм, журмуудын хоорондын уялдаа холбоог хангахыг зорьж байна, цөөн хүн амтай улсуудын авлигатай тэмцэх стратеги, АТГ 2022 онд хохирол нөхөн төлүүлэлтийн мэдээлэл, Шүгэл ажиллагааг хэрэгжүүлж, иргэдтэй хамтарч ажиллах ажлын хэсэг байгуулагдсан зэрэг нийтлэл ярилцлага, "Шудрага ёс" сэтгүүлийн 2023 оны дугаар хэвлэгдэн гарлаа, “Авлигын эсрэг үндэсний чуулганы илтгэл” зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудасны урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх буланд байршуулсан.

					Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх 5 ажиллагааны нэг болох "Шүгэл" ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан зурагт хуудас, мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулж мэдээлэлсэн. Мөн "Шүгэл ажиллагаанд нэгдье" зурагт танилцуулгыг цахим хуудасны нүүрэнд байршуулсан. Мөн байгууллагын олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-гээр дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагаа сурталчилсан. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн самбарт Авлигатай тэмцэх газраас бэлгэсэн контент, зурагт хуудас, нугалбар зэрэг мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэн ажилласан. Тус газрын хэмжээнд нийт 14 видео, танилцуулга, нийтлэлийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын болон тус байгууллагын олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-т 170 удаа зурагт хуудас болон мэдээ, мэдээлэл оруулсан байна.
Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг харьяа байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	Жилдээ	-Хоёроос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; - Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	-Мэдээ, мэдээлэл нь олон нийтэд хүрсэн байна.	"Барилга байгууламжийн чанарын улсын зөвлөгөөн-2023" арга хэмжээний "Барилгын чанар, аюулгүй байдал-паспортжуулалт" сэдэвт формыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулагдсан. Форумд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Газрын харилцаа, Геодези зураг зүйн газар, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар болон 21 аймгийн Газар зохион байгуулалт, барилга, хот байгуулалтын газрууд, 15 төрийн бус байгууллага, салбарын 30 орчим аж ахуйн нэгжийн 250 гаруй төлөөлөл оролцсон. Оролцогч нарт "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа", "Шүгэл	

					<p>ажиллагаанд нэгдье” сэдэвт зурагт хуудсыг оролцогч бүрт тараасан.</p> <p>Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газрын авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд авлигын индексийг бууруулах, төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээнд дүн шинжилгээ хийх, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба болон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/78 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг хийх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>  <p>Газрын харилцааны салбарын албан хаагчдад зориулсан сургалтыг АТГ-тай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын танилцуулга, Авлигын хор хөнөөл, ангилал, авлигын эсрэг манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг болон хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээллэсэн. Сургалтад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нэгжийн дарга нар болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны нэгжийн дарга нар, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нягтлан бодогч нар танхимаар, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, нэгжийн дарга нар, улсын байцаагчдыг цахимаар хамруулан зохион байгуулав. Сургалтад танхимаар-57, цахимаар-123, нийт-180 албан хаагч хамрагдсан.</p>
--	--	--	--	--	---

		Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Жилдээ	- Мэдээллийг сар бүр шинэчлэх; - Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	-Мэдээлэл тогтмол шинэчлэгдсэн байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг байгууллагын үүдэнд байршуулсан. Авлигатай тэмцэх газраас нээсэн шударга ёс, хөгжил дэвшилд самбар хариуцсан албан хаагчид класс рүүмд нэгдэж мэдээллийг авч самбарын мэдээллийг шинэчлэн ажилласан. 2023 оны жилийн байдлаар 2 удаа бүрэн шинэчилсэн.
		Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх.	Жилдээ	-Хоёроос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; - Авлигыг мэдээлэх утас 110 дугаарыг дурдсан байх	-Мэдээлэл тогтмол шинэчлэгдсэн байна.	Барилга, хот байгуулалтын яамтай хамтран “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” сэдэвт зурагт хуудас хэвлүүлэн албан хаагчдын өрөө болон иргэд олон нийт үйлчлэх хэсэгт байршуулсан.  
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах,	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах	Жилдээ	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-Сургалтад хамрагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр томилогдсон 5 албан хаагчийг авлигын эсрэг үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл өгч ажилласан.

	сургалтад хамруулах	Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчилах арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	-хоёроос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байх	-Зохион байгуулагдсан байна.	2022 онд Монголын кадастрын холбоо болон Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ-тай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бэлчээрийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг сайжруулах, малын гаралтай бүтээгдэхүүний үнэлэмжийг бэлчээрийнх нь чанар, төлөв байдал, малчдын мал маллагааны онцлог, үр нөлөөнд үндэслэн тооцох замаар бэлчээрийн тогтвортой менежментийг хэвшүүлэх, улмаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, хариуцлагатай үйлдвэрлэлийг төлөвшүүлэх зорилготойгоос гадна салбарын хөгжлийг дэмжих, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, газар зохион байгуулалт, газрын кадастр, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлуудыг хийж гүйцэтгэх арга зүй, норм, стандартуудыг боловсруулах, сайжруулах, албан хаагчдын ёс зүй, хандлагын талаар сургалт зохион байгуулахаар ажиллаж байна.
		Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах	Жилдээ	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-Сургалтад хамрагдсан байна.	Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчид болон сумын газрын даамлуудад 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулагдсан. Сургалтад хөтөлбөрт Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системийн хэрэглээ, сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал, Газрын мониторингийн системийн үйл ажиллагаа, газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээг ажиллуулах, газар хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа, Газрын кадастрын мэдээллийн системийн хэрэглээ, иргэн хуулийн этгээдэд үзүүлж буй цахим үйлчилгээ, газрын кадастрын мэдээллийн системд хийгдэж буй хянал шалгалт Газрын тухай хуулийн хэрэгжилт,

					<p>Засаг даргын захирамжийн төсөл боловсруулахад анхаарах асуудлууд болон Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал сэдэвт илтгэлүүдийг танилцуулсан. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, эрх шилжүүлэх, хугацаа сунгах захирамжийн төсөл боловсруулахад ашиг сонирхол гэж юу вэ? ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал гэж юу вэ? яаж урьдчилан сэргийлэх вэ? өөрийгөө яаж хамгаалах вэ? зэрэг ойлголтуудыг өгч, сонирхсон асуултад хариулт өгсөн. Сургалтад нийт 32 албан хаагч хамрагдсан.</p>  <p>2023 онд Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль тогтоомж, Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, Архив, албан хэрэг хөтлөлт болон Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал, Кадастр, Газар зохион байгуулалт, Геодези, зураг зүйн, Суурь, судалгаа мониторингийн болон Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр 4 ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн удирдамж батлагдсан.</p>
--	--	--	--	--	---

						<p>Ажлын хэсэг 2023.10.03-10.12-ны өдрүүдэд Дорноговь, Өмнөговь, Дундговь аймагт, Дархануул, Сэлэнгэ аймагт 2023.10.06-10ны өдрүүдэд, Хэнтий, Дорнод аймагт ажиллах ажлын хэсэг 2023.10.16-2023.10.23-ны хооронд ажиллаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сургалт зохион байгуулсан. Сургалтын хүрээнд 2024 онд хийх сургалтын хүсэлт, судалгаа авч ажилласан.</p> <p>Нийслэлийн ГЗБА-нд 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр ажлын хэсэг очиж удирдамжийг танилцуулж, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг 10 сард дүүргийн ГЗБА-ны үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсгүүд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг газрын даргын дэргэдэх 12 дугаар зөвлөлийн хуралд танилцуулж, аймгийн ГХБХБГ, Нийслэл, дүүргийн ГЗБА, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга болон агентлаг тус бүрт зөвлөмжийг өгч ажилласан.</p>
3	<p>Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</p>	<p>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>	<p>Тухай бүр</p>	<p>-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх</p>	<p>-Зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Тус агентлагийн албан хаагчдаас болон бусад холбогдох байгууллагаас боловсруулсан гэрээний төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу нэн даруй мэдэгдэх талаар тусган холбогдох албан тушаалтнуудаар батлуулан ажиллаж байна. Тус агентлагийн албан хаагчдаас болон бусад холбогдох байгууллагаас боловсруулсан гэрээний төслийг хянан эрх зүйн үндэслэлийг хангуулан санал өгч, хяналт тавин ажилласан. Тус агентлагт 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт-187 иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Гэрээний авлигатай холбоотой заалтыг тухай бүр оруулж, ажилласан.</p>

		“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	Тухай бүр	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх	-Нотлох баримт, шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.	Тус байгууллага Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох урьдчилсан дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулдаг. Дээрх ажлын хэсэгт Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо, Газар зохион байгуулагчдын холбооноос төлөөлөл оролцуулан хурлыг зохион байгуулдаг бөгөөд 2021 оноос эхлэн тусгай зөвшөөрлийн материалыг цахим системээр дамжуулан авч эхэлсэн. Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд дараах арга хэмжээг тусгуулахаар Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнд: 1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох чиг үүрэг 2.Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох чиг үүрэг 3.Газар зохион байгуулалт, газрын кадастрын салбарын мэргэжилтнүүдийн сургалтын чиг үүрэг 4.Геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнүүдийн сургалтын чиг үүрэг.
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж,	Жилдээ	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; - Тайланд нотломжийг	-Үйлчилгээ цахим болсон байна.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, хүнээс хамаарах хамаарлыг багасгах үүндээс Газрын удирдлагын нэгдсэн цахим системд дараах нэмэлт хөгжүүлэлт болон өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Газар зохион байгуулалт, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн талаарх статистик мэдээллийг агуулсан дашбоард, Засгийн газрын “Шилэн ажиллагаа”-ны хүрээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад олгосон газрын захирамжийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх дэшбоардыг “Софт мастер” ХХК-аар гүйцэтгүүлэх ажлыг

		асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн хийлгэх г.м/ үнэлгээ		хавсаргасан байх	<p>зохион байгуулан egazar.gov.mn-д байршуулсан болно.</p> <p>-2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 3019 газрын дуудлага худалдааг зохион байгуулсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 2635 нь цахим хэлбэрээр, 384 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 4866 иргэн, хуулийн этгээд оролцож, 15.9 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 141 газрын газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. 54 төсөл сонгон шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулсан.</p> <p>-Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс гаргах цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлж, иргэдэд хүргэх ажлын хүрээнд И-Монголиа академитэй хамтран ажиллаж, Газрын кадастрын мэдээллийн системээс үзүүлж буй үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн кадастрын зургийн хэлбэр, байршил өөрчлөх, газар эзэмших эрх шилжүүлэх, газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, газар эзэмших зориулалт өөрчлүүлэх, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа сунгуулах зэрэг нийт 21 төрлийн үйлчилгээний дэлгэрэнгүй судалгааг боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр И-Монголиа академид хүргүүлсэн.</p> <p>- 66 төрлийн салбарын нээлттэй өгөгдлийг төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем www.opendata.gov.mn-д хуваарийн дагуу байршуулж, шинэчлэлт, хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж ажилласан.</p> <p>- Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд өгөгдөл оруулах дээд хэмжээ 30мб байсныг тус газрын 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/143 тоот албан бичгээр хүсэлт гаргаж 4гб файл нэмэх боломжтой болгон шинэчлүүлсэн.</p> <p>- Шинээр нээлттэй өгөгдөл бий болгох талаар ирсэн хүсэлтийг судалж өвөлжөө, хаваржааны байршлын өгөгдлийг нэмж json форматаар байршуулсан.</p>
--	--	--	--	------------------	--

					<p>- ЦХХХЯ-наас ирүүлсэн 03/489 тоот албан бичгийн дагуу тус газрын нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны 2022 оны мэдээ татан авалтын тайлан болон 2023 оны нийтлэх төлөвлөгөөг газрын даргаар батлуулж хүргүүлсэн.</p> <p>- Мөн газрын даргын А/69 тоот тушаалаар байгууллагын нээлттэй өгөгдлийн жагсаалтыг шинэчлэн батлуулж Засгийн газрын 232 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг 1/825 тоот албан бичгээр ЦХХХЯ-нд хүргүүлсэн.</p>
	Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгах	Жилдээ	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх	-Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Удирдах ажилтны зөвлөгөөнд аймгийн ГХБХБГ болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын дарга нар оролцсон. Зөвлөгөөнд “Шинэ сэргэлтийн бодлого, түүнийг орон нутагт хэрэгжүүлэх” сэдэвт илтгэлийг Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвийн Дэд бүтцийн хөгжлийн бодлогын газрын дарга Н.Батдорж, Шинэ супервайзор, менежерүүдэд зориулсан менежмент сэдэвт илтгэлийг Дэйл карнеги Трэйнингийн үүсгэн байгуулагч Б.Энхболд нар танилцуулсан. Мөн “Орон нутагт хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад гарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг үеэр Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах асуудал хөндөгдсөн. Тулгамдаж буй асуудал нь хууль эрх зүйн орчин тодорхойгүй, хөрөнгө төсөв байхгүй, улс төрийн нөлөөлөл их байна гэж үзсэн. Цаашид дээрх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахаар зөвлөгөөнөөс гарч буй санал дүгнэлтэд туссан. 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр “Нийслэлийн замын хөгжлийн газар”-аас “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын төлөвлөлтийн авто замын *.gdb өргөтгөлтэй орон зайн өгөгдлийг цахимаар хүлээн авч боловсруулан нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 3896.6 км төлөвлөлтийн авто

						замын орон зайн мэдээллийг бүрдүүлсэн болно. Хот байгуулалтын кадастрын цахим системийн хөгжүүлэлтийн ажил дууссаны дараа мэдээллийн санд бүртгэхээр ажиллаж байна. Барилга хот байгуулалтын яам, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг нэг болгох үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс Авлигатай тэмцэх газартай хамтран Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар болон холбогдох байгууллагын төлөөллийг зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.
		Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	-Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Тус газрын даргын 2020 оны А/219 дугаар тушаалаар батлагдсан “Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баталсан. Журамд Хэрэглэгчийн үнэлгээний картын аргын асуулга” /хавсралт2/ баталсан бөгөөд Хэрэглэгчийн үнэлгээг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн орон нутгийн эрх зүйн чадамжтай 30-аас доошгүй иргэдийн төлөөллийг хамруулж авахаар журамд тусгасан. Хэрэглэгчийн үнэлгээний картын аргын асуулгын үнэлгээг хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээнд оруулан дүгнэхээр зохицуулсан. 2023 оны 3 дугаар улиралд 7 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөж байгаа бөгөөд үнэлгээний үеэр хэрэглэгчийн үнэлгээг авсан. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүртээмжтэй болгох үүднээс иргэний газар эзэмших эрхийг цахим системээр гаргах эрх зүйн орчин болон цахим системийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд,	Жилдээ	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал	-Албан хаагчдад танилцуулсан байна.	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинээр боловсруулж, газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/25 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний төслийг “Байгууллагын удирдлагын систем”-ийн олон нийтэд байршуулан албан хаагчдаас санал авсан

		хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах		санаачилгыг хэлэлцсэн байх;		бөгөөд, батлагдсан төлөвлөгөөг мөн системд байршуулан хэрэгжилтийг хангах ажиллаж байна. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сард нийт албан хаагчдад танилцуулсан.
		Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган ажиллах	Жилдээ	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-Санал авсан байна.	Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах”, 23 дугаар зүйлийн 23.2.13 “газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг батлах”, Засгийн газрын 2020 оны 110 дугаар “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” тогтоолын 2.1 дэх заалтад “Тухайн жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд олон нийтийн саналыг авах, төлөвлөх, батлагдсан төлөвлөгөөг мэдээлэх, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу газрын эрх олгох асуудлыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэнэ” гэж заасныг тус тус үндэслэн тус газрын даргын баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Нэмэлт өөрчлөлтийн төсөлд Авлигатай тэмцэх газарт хүргүүлж санал авсан. Журмыг батлуулан эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн.
		Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах	Жилдээ	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khtulbur.iaас.mn цахим санд нэмж оруулсан байх, - тайлагнасан байх.	-Хэрэгжсэн байна.	Шудрага байдлын үнэлгээний тайланд агентлагуудын бодлогод оролцогчдын үнэлгээгээр тус газар 2021 онд 1-д жагсаж байсан бол 2022 оны судалгаагаар 26-д жагссан байна. Судалгаанд хамрагдсан үнэлгээ, асуулгыг судлан үзэхэд үнэлгээнд оролцогчдын авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бага байна гэж үзсэн байна. Тиймээс 2023 онд газрын удирдлага болон салбар нэгжийн удирдах албан тушаалтнуудад авлигын эсрэг сургалтад хамруулах, соён гэрээрүүлэх чиглэлээр түлхүү ажиллахаар төлөвлөж байна. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан байгууллагаар Эрүүл

						мэндийн байгууллага, Шүүх, Газрын алба, Гаалийн байгууллага, Цагдаагийн газар гэж үнэлж эрэмбэлэгдэж байна. Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан салбарын хэмжээнд авлигыг бууруулах чиглэлээр ахиц гаргах томоохон арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
		Газрын удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах өргөдөл хүлээн авах боломжийг бүрдүүлэх, хориглох, хязгаарлах бүсийг олон нийтэд нээлттэй болгох Нотариатын гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн өргөдлийн хүсэлт газрын кадастрын системд шууд үүсгэх боломжийг бүрдүүлж, автоматжуулах, Газрын цахим систем /egazar.gov.mn/ болон газрын харилцааны киоск машинаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг төлбөр тооцооны системд шилжүүлэх боломжийг бүрдүүлэх	4 дүгээр улиралд	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; Тайланд нотломжийг хавсаргасан байх	-Хэрэгжсэн байна.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулахтай холбогдуулан Монгол Улсын засгийн газрын тухай хууль, Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал болон газрын кадастрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж 2023.11.10-ны өдөр батлагдсан. Газрын тухай хууль болон бусад хуульд орсон өөрчлөлтөөр дараах асуудлууд туссан. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн газар чөлөөлөх журам болон Цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар батлуулна. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газартай холбоотой маргааныг нийслэлийн маргаан таслах зөвлөл ажиллана. Улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар дээр нийтийн болон хувийн сервитут тогтоох, Газар эзэмших эрх шилжих, хугацаа сунгах шийдвэрийг Нийслэл, дүүргийн Газрын алба гаргаж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломж нээгдсэн. Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний газрыг эзэмших хүсэлтээ цахим системээр гаргаж, цахим систем эрэмбэлэн газар олгох үйл ажиллагааг хүртээмтэй шуурхай хэрэгжүүлэх боломжтой

					<p>болсон. Салбарын төрийн хяналт шалгалтыг зөвхөн нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж байсан бол улсын хэмжээнд хэрэгжүүлж эхлэнэ. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих, Улсын хэмжээнд 330 сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих боломжийг эрх зүйн хувьд бүрдүүлсэн.</p> <p>“Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангах” ажлыг урсгал зардлаар гүйцэтгүүлэхээр байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Газрын цахим систем /egazar.gov.mn/ болон газрын харилцааны киоск машинаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг төлбөр тооцооны системд шилжүүлэх зэрэг ажлыг “Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгасан. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийг www.tender.gov.mn цахим системээр зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг бүрэн хүлээн авсан.</p>
--	--	--	--	--	--

_ o O o _